

ТУЗ-ийн гишүүдийн ажлын байр (албан тушаал)-ны тодорхойлолт

1. Албан тушаалын нэр:

ТУЗ-ийн гишүүний албан тушаал нь ХЭХ-ын бусад цагт компанийн эрхийг барьдаг ТУЗ-ийн бүрэлдэхүүний нэг хэсэг. Энэ утгаар нь ТУЗ-ийн гишүүнийг ХЭХ-аас сонгогдог бөгөөд компанийн тухай хуульд заасны дагуу зохих шаардлага хангасан хувь хүн ажилладаг албан тушаал юм.

ТУЗ-ийн гишүүний албан тушаал нь Компанийн тухай хуульд заасны дагуу ТУЗ-ийн ердийн гишүүн, хараат бус гэсэн хоёр төрөлтэй.

Ердийн гишүүн (nominee director) нь ХЭ болон Компанийн тухай хуульд заасан бусад эрх бүхий этгээдээс нэр дэвшүүлэн томилуулсан гишүүний албан тушаал;

Хараат бус гишүүн (independent director)-ний албан тушаал гэдэг нь компанийн Гүйцэтгэх удирдлага, компанийн хяналтын багц эзэмшигч болон төрөөс ямар нэг хамааралгүй бөгөөд түүнд нь тулгуурлан ТУЗ-ийн дэргэдэх Нэр дэвшүүлэх хорооноос Компанийн тухай хуульд заасны дагуу нэр дэвшүүлсэн гишүүний албан тушаал;

2. Албан тушаалын ажиллах горим:

ТУЗ-ийн гишүүн нь компанид бүтэн цагаар ажиллахгүй, зөвхөн ТУЗ болон түүний дэргэдэх хорооны хурлаар хэлэлцэх асуудалд өөрийн саналыг бэлтгэх, хуралд оролцох, хэлэлцсэн асуудлаар гарах шийдвэрт санал өгөх хэлбэрээр ажилладаг албан тушаалтан байна.

3. Албан тушаалд тавигдах шаардлага:

ТУЗ-ийн гишүүн болох хүнд тавих нийтлэг шаардлага:

- **Хувь хүний хувьд дараах нийтлэг шаардлагыг хангасан байна:**
 - ТУЗ-ийн ажилд оролцох ажлын зав чөлөөтэй байх;
 - Багаар ажиллах хүсэл, чадвартай байх;
 - Хувь хүний хувьд нэр хүндтэй, үнэнч шударга, хариуцлагатай байх;
 - Ял шийтгэл эдэлж байгаагүй байх;
- **Мэргэжлийн хувьд дараах нийтлэг чиглэлээр мэргэжсэн байна:**
 - Санхүү, эдийн засаг
 - Менежмент
 - Хямралын үеийн удирдлага
 - Санхүү, мөнгөний зах зээлийн хэрэгсэл
 - Банк, санхүүгийн чиглэлийн мэргэжил
- **Дадлагажсан чадварын хувьд дараах нийтлэг шаардлагыг хангасан байна:**
 - Компанийн засаглал ба эрх зүйн чиглэл;
 - Стратегийн болон бизнес төлөвлөгөө боловсруулах чиглэл;
 - Санхүүгийн болон үйл ажиллагааны тайлан, балансыг уншиж шинжилгээ хийх чиглэл;
 - Үнэт цаас гаргах, хөрөнгө оруулалтын чиглэл
 - Татварын тогтолцоо
 - Санхүүгийн зүй бус ажиллагаа, алдааг илрүүлэх чиглэл;
 - Мөнгө угаах, террорист үйл ажиллагааны санхүүжилт

4. ТУЗ-ийн гишүүний албан тушаалд ажиллагчийн үндсэн эрх, үүрэг:

ТУЗ нь нэгдүгээрт хамтын удирдлагын байгууллага, хоёрдугаарт ТУЗ-ийн үйл ажиллагаа явуулах үндсэн хэлбэр нь Компанийн тухай хуульд заасны дагуу түүний хурал байдаг. Иймд ТУЗ-ийн гишүүн нь дангаараа шийдвэр гаргадаггүй бөгөөд ТУЗ-ийн гишүүний үндсэн эрх, үүрэг нь тус хуралд оролцож зөвхөн хурлаар хэлэлцэж буй асуудалд өөрийн санал, бодлоо хэлж хэлэлцүүлэгт оролцож хурлаас гарах шийдвэрт өөрийн саналыг зохих журмын дагуу өгөх явдал юм.

Энэхүү үндсэн эрх, үүргээ хэрэгжүүлэхтэй холбогдуулан ТУЗ-ийн гишүүний албан тушаалд ажиллагч нь дараах эрх, үүрэг хариуцлагыг хүлээж ажиллана.

• Гишүүний албан тушаалд ажиллагчийн эдлэх эрх:

- Гишүүн нь ТУЗ-ийн хурлаар хэлэлцэж буй асуудал болон гишүүний хувьд хариуцсан ажилтайгаа холбогдуулан компанийн өнөөгийн байдал болон цаашид хийх ажлын талаарх мэдээллийг ТУЗ-ийн дарга, нарийн бичгийн дарга болон ТУЗ-ийн дэргэдэх ажлын алба зэргээр дамжуулан компаниас гаргуулан авах;
- Тодорхой асуудал (ТУЗ-ийн бүрэн эрхийн хүрээний)-ыг хэлэлцүүлэхээр ТУЗ-ийн хурлыг зарлан хуралдуулах саналыг ТУЗ-ийн даргад гаргах;
- Тодорхой асуудлаар ГУ-ын сонсголыг сонсох саналыг ТУЗ-ийн даргад тавих;
- ТУЗ-ийн хурлаас ТУЗ-ийн болон түүний дэргэдэх хорооны даргад нэрээ дэвшүүлэх, олонхын саналаар даргад томилогдох;
- Ердийн гишүүний хувьд дараах нэмэлт эрх эдэлнэ:
 - ТУЗ-ийн хурлаар хэлэлцэж буй асуудлаар Өөрийнх нэрийг дэвшүүлэн гишүүнээр томилуулсан этгээдэд өөрийн гаргах саналынхаа агуулгыг компанийн эрх ашигтай уялдуулан танилцуулан гаргах саналаа тохиролцох;
- Хараат бус гишүүн нь дараах нэмэлт эрх эдэлнэ:
 - Компанийн үйл ажиллагааны ил тод, нээлтэй байдал, түүний хэрэгжилтийн талаар тодорхой мэдээлэл авах,
 - Компани дээр хийгдэж буй их болон сонирхлын зөрчилтэй хэлцлийн хэрэгжилтийн талаар тодорхой мэдээлэл авах,
 - Хараат бус гишүүд дангаараа хуралдах, тодорхой асуудлаар саналаа солилцох, зөв гэж хамтаараа тохирсон асуудлаар нэгдсэн санал дүгнэлт гаргах;
 - Компанийн эрх ашигтай холбоотой асуудлаар ТУЗ-ийн болон ХЭХ-ыг хуралдуулах саналыг ТУЗ-ийн даргад тавьж шийдүүлэх;

• Гишүүний албан тушаалд ажиллагчийн Хүлээх үүрэг:

- Гишүүн нь ТУЗ-ийн хурлаар хэлэлцэж буй асуудлаар бүрэн мэдээлэлтэй байж хуралд оролцож түүндээ үндэслэн өөрийн санал бодлоо гаргах;
- Гишүүн бүр компанитай холбоотой аливаа ажиллагаанд хандахдаа компанийн эрх ашгийг хувийн эрх ашгаас дээгүүрт тавих зарчмыг баримтлах;
- Гишүүд нь ТУЗ-ийн аль нэг болон хэд хэдэн хороонд орж ажиллах;
- ТУЗ-ийн гишүүнээр сонгогдсоны дараа өөрийн нэгдмэл сонирхолтой этгээдийнхээ талаарх мэдээлэл, түүнд орсон өөрчлөлтийг цаг тухайд компанид ирүүлэх;
- **Ердийн гишүүний хувьд дараах нэмэлт үүргийг хүлээнэ.**
 - Компани дээр болж буй үйл ажиллагаа болон ТУЗ-ийн хурлаар хэлэлцэх гэж буй асуудлаар өөрийн нэрийг дэвшүүлэн гишүүнээр томилуулсан этгээдэд мэдээлэх, энэ талаараа уг этгээдтэй хэлэлцэн өөрийн баримтлах чиглэлээ тохиролцох;
 - ТУЗ-ийн хурлаар хэлэлцэж буй асуудлаар санал гаргахдаа өөрийн нэрийг дэвшүүлэн гишүүнээр томилуулсан этгээдийн саналыг удирдлага болгох. Энэхүү удирдлага болгосон санал нь компанийн эрх ашигт муугаар нөлөөлөхөөр бол энэ талаараа өөрийнх нь нэрийг дэвшүүлсэн этгээдэд мэдэгдэн ойлгуулсан байх;

- **Хараат бус гишүүн нь дараах нэмэлт үүрэг хүлээнэ:**
 - Компани дээр хийгдэж буй их болон сонирхлын хэлцлүүдэд хяналт тавих, түүнийг батлахад компанийн эрх ашгийг хамгаалсан санал өгөх
 - Компанийн үйл ажиллагааны ил тод, нээлтэй байдал, түүний хэрэгжилтэнд хяналт тавих, шаардлагатай бол энэ талаар ГУ-д зөвлөмж, шаардлага хүргүүлэх;
 - ХЭХ-д биечлэн оролцох, өөрийн хариуцсан ажилтай холбоотой ХЭ-ийн асуултанд хариу өгөх, ТУЗ-өөс гарсан шийдвэрт зөрүүтэй байсан саналынхаа талаар мэдэгдэл хийх
 - Хараат бус гишүүн нь Монголбанкаас гаргасан журмын дагуу дараах зүйлийг тусгасан өөрийн ажлын тайланг улирал бүр дараа сарын 15-ны өдрийн дотор Монголбанкинд хүргүүлэх:
 - Оролцсон ХЭХ, ТУЗ-ийн хурал, Хороодын хуралд оролцсон ажлын тайлан, хурлын огноо, хурлын шийдвэр;
 - Дээрх хурлын шийдвэртэй зарчмын зөрүүтэй байр суурьтай байсан эсэх, зарчмын зөрүүтэй байр суурьтай байсан бол энэ тухай тайлбар, гаргасан санал;
 - Их хэмжээний хэлцэл, сонирхлын зөрчилтэй хэлцлийг батлахад оролцсон тухай тайлан, өгсөн санал;
 - Компанийн тухай хуулийн 79.3-т заасан үүрэг тус бүрээр хийж гүйцэтгэсэн ажлын дэлгэрэнгүй тайлан;
 - Банкны дүрэм, Банкны тухай хууль, Компанийн тухай хуульд заасан хараат бус гишүүний эрх, үүргийн хүрээнд аливаа зөрчил, дутагдлыг арилгах, хяналт тавих хүрээнд тавьсан санал, шаардлага, тэдгээртэй холбоотой баримт бичгийн хуулбар.
- **Гишүүний албан тушаалд ажиллагчийн Хүлээх хариуцлага:**
 - Гишүүн нь ТУЗ-ийн хурлаар хэлэлцсэн асуудлаар өөрийн хэлсэн үг, гаргасан саналынхаа төлөө өөрийн хувийн хөрөнгөөр хариуцлага хүлээх;
 - Хараат бус гишүүний бүрэн эрхийг Монголбанкаас гаргасан журмын дагуу дараах үндэслэлээр ХЭХ-ын шийдвэрээр хугацаанаас нь өмнө дуусгавар болгож чөлөөлнө:
 - Хараат бус гишүүн нь Банкны тухай хууль, Компанийн тухай хууль болон энэхүү журамд заасан холбогдох шалгуурыг хангахгүй болсон;
 - ТУЗ-ийн хурал, аудитын болон эрсдэлийн удирдлагын хорооны хуралд хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр жилд 2-оос дээш удаа оролцоогүй;
 - Ашиг сонирхлын зөрчил үүссэн;
 - Биеийн эрүүл мэндийн байдал, эсвэл хүндэтгэн үзэх бусад шалтгаанаар албан үүргээ цаашид гүйцэтгэх боломжгүй гэж үзэж, уг ажлаас чөлөөлж өгөх хүсэлт гаргасан;
 - Өөрийн ажлын талаар Монголбанкинд тайлагнах үүргээ биелүүлээгүй;

5. Албан тушаалд ажиллах хугацаа:

Гишүүний бүрэн эрхийн хугацаа нь хэрэв өөрийг нь анх томилсон шийдвэрт тодорхой хугацаа заагаагүй бол өөрийг томилсны дараа болох ХЭ-ийн ээлжит хурал хүртэл байна.

6. Албан тушаалд ажиллах хүнд олгох цалин, урамшуулал

ТУЗ-ийн гишүүнд дараах байдлаар цалин урамшуулал олгоно:

- ТУЗ-ийн гишүүний албан тушаалд сонгогдсоных нь хувьд олгох цалин. Энэ нь нийт олгох дүнгийн нэлээд бага хувь нь байна.
- Дээрх цалин дээр ТУЗ-ийн ажилд оролцсоных нь хувьд дараах нэмэгдлийг олгоно:
 - ТУЗ-ийн хуралд оролцсоны нэмэгдэл;
 - ТУЗ-ийн дэргэдэх хорооны гишүүний нэмэгдэл;
 - ТУЗ-ийн дэргэдэх хорооны хуралд оролцсоны нэмэгдэл;
 - ТУЗ-ийн дэргэдэх хорооны даргын албан тушаалын нэмэгдэл;
 - ТУЗ-ийн хараат бус гишүүний үүргийг гүйцэтгэсний нэмэгдэл;
- Дээр дурдсан цалин болон нэмэгдлийн хэмжээг компанийн тухайн жилийн санхүүгийн байдалтай уялдуулан компанийн ГУ-аас ирүүлсэн саналыг үндэслэн Компанийн ТУЗ-ийн зардлын төсвийн хүрээнд нэгдсэн байдлаар компанийн жил бүрийн ХЭ-ийн ээлжит хурлаас батална.

7. Албан тушаалд ажиллагчийн ажлын тайлагналт, тайлагнах хугацаа:

Гишүүн нь өөрийн хийсэн ажил, гишүүнийхээ үүргийг гүйцэтгэсэн тухай ТУЗ-ийн даргаар дамжуулан ТУЗ-ийн хуралд жилд нэгээс доошгүй удаа тайлагнана.

Хараат бус гишүүн нь Монголбнкнаас гаргасан журмын дагуу өөрийн ажлын тайланг хагас жил тутам олон нийтэд мэдээлнэ.

8. Албан тушаалд ажиллагчийн ажлыг дүгнэх

Гишүүний ажлыг ТУЗ-ийн ажлыг дүгнэх журамд заасан асуулгын хүрээнд жилд нэгээс доошгүй удаа 360° -ийн аргаар дүгнэж байна.

Энэхүү албан тушаалтны ажлын байрны тодорхойлолттой танилцсан

ТУЗ-ийн гишүүн / /